



Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2023 онд 7.5 их наяд төгрөг болж, 7.2 (96.4%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 270.3 (3.6%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.

Барилга угсралт, их засварын ажил 2023 онд өмнөх оноос 1.1 (17.1%) их наяд төгрөгөөр өсөхөд дотоодын байгууллагын барилгын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 956.0 (15.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн.



Барилга угсралт, их засварын ажил, гүйцэтгэгчийн төрлөөр, тэрбум төгрөгөөр

| Төрөл | 2020 | 2021 | 2022 | 2023* | Өөрчлөлт | |
|-----------------------------|---------|---------|---------|---------|----------|------------------|
| | | | | | Дүн | Хувь |
| Нийт | 5 301.0 | 4 647.6 | 6 401.1 | 7 493.2 | 1 092.1 | 17.1 |
| Дотоодын байгууллага | 5 186.1 | 4 543.0 | 6 266.9 | 7 222.9 | 956.0 | 15.3 |
| Төрийн | 539.2 | 287.8 | 128.9 | 132.3 | 3.4 | 2.6 |
| Хувийн | 4 568.6 | 4 206.1 | 6 090.9 | 7 030.4 | 939.5 | 15.4 |
| Гадаадтай хамтарсан | 78.3 | 49.1 | 47.2 | 60.3 | 13.1 | 27.9 |
| Гадаадын байгууллага | 114.9 | 104.6 | 134.2 | 270.3 | 136.1 | 2.0 ¹ |



Дотоодын барилгын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 7.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 939.5 (15.4%) тэрбум төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагынх 60.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 13.1 (27.9%) тэрбум төгрөгөөр, төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 132.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 3.4 (2.6%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.



Энэ онд барилга угсралт, их засварын ажлын 40.2 хувийг орон сууцны барилга, 33.9 хувийг орон сууцны бус барилга, 22.1 хувийг инженерийн барилга, байгууламж, 3.8 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оноос орон сууцны бус барилгын ажлын эзлэх хувь 5.8 нэгж хувиар, орон сууцны барилгынх 1.3 нэгж хувиар, их засварын ажил 0.7 нэгж хувиар тус тус өссөн бол инженерийн барилга, байгууламжийнх 7.8 нэгж хувиар буурсан байна.



БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, жил бүрийн эцэст, тэрбум төгрөг



Эх сурвалж: ҮСХ, Барилга байгууламж, объектын улирлын мэдээ (ББО-1)



БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, барилгын төрлөөр, жилээр

| Барилгын төрөл | 2020 | 2021 | 2022 | 2023* | 2023* |
|---------------------------------------|--------------------|--------------------|--------------------|--------------------|-------------------|
| | сая төгрөг | | | | 2022 |
| | | | | | хувь |
| Дүн | 5 300 974.4 | 4 647 626.7 | 6 401 146.1 | 7 493 249.3 | 17.1 |
| Орон сууцны барилга | 1 835 855.7 | 1 719 444.5 | 2 492 803.6 | 3 013 012.3 | 20.9 |
| Орон сууцны бус барилга | 1 778 406.4 | 1 476 808.6 | 1 797 384.9 | 2 539 657.8 | 41.3 |
| Үйлдвэрийн | 709 919.5 | 749 223.4 | 729 456.9 | 920 045.3 | 26.1 |
| Худалдаа, үйлчилгээний | 145 840.6 | 125 609.1 | 195 578.4 | 314 260.5 | 60.7 |
| Эмнэлгийн | 89 919.1 | 57 416.5 | 68 064.6 | 132 594.0 | 94.8 |
| Сургууль, соёлын | 511 697.6 | 338 168.0 | 422 302.5 | 656 214.6 | 55.4 |
| Бусад | 321 029.6 | 206 391.6 | 381 982.5 | 516 543.5 | 35.2 |
| Инженерийн барилга, байгууламж | 1 540 314.3 | 1 326 541.1 | 1 915 307.3 | 1 656 456.5 | -13.5 |
| Эрчим хүчний | 52 599.3 | 27 981.7 | 97 971.9 | 231 376.0 | 2.4 ¹ |
| Холбооны | 520.2 | 1 907.2 | 1 424.7 | 21 939.4 | 15.4 ¹ |
| Төмөр зам | 840 380.0 | 856 321.6 | 1 282 868.0 | 388 827.0 | -69.7 |
| Авто зам | 432 104.8 | 284 900.7 | 274 483.2 | 525 814.8 | 91.6 |
| Гүүр, гүүрэн гарц | 14 634.9 | 22 238.5 | 30 695.9 | 63 431.1 | 2.1 ¹ |
| Далан, суваг, шугам, сүлжээ | 117 654.5 | 76 499.5 | 132 750.6 | 241 438.7 | 81.9 |
| Бусад (зам, талбайн бусад ажил) | 82 420.7 | 56 691.9 | 95 113.2 | 183 629.5 | 93.1 |
| Их засварын ажил | 146 397.9 | 124 832.5 | 195 650.3 | 284 122.7 | 45.2 |

¹ Дахин их




ОРОН СУУЦНЫ БУС БАРИЛГА, ЖИЛ БҮРИЙН ЭЦЭСТ, ТӨРЛӨӨР, ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР

| Төрөл | 2020 | 2021 | 2022 | 2023* | Өөрчлөлт | |
|--------------------------------|---------|---------|---------|---------|----------|------|
| | | | | | Дүн | Хувь |
| Орон сууцны бус барилга | 1 778.4 | 1 476.8 | 1 797.4 | 2 539.7 | 742.3 | 41.3 |
| Үйлдвэрийн | 709.9 | 749.2 | 729.5 | 920.0 | 190.6 | 26.1 |
| Худалдаа, үйлчилгээний | 145.8 | 125.6 | 195.6 | 314.3 | 118.7 | 60.7 |
| Эмнэлгийн | 89.9 | 57.4 | 68.1 | 132.6 | 64.5 | 94.8 |
| Сургууль, соёлын | 511.7 | 338.2 | 422.3 | 656.2 | 233.9 | 55.4 |
| Бусад | 321.0 | 206.4 | 382.0 | 516.5 | 134.6 | 35.2 |

Орон сууцны бус барилгын ажил 2023 онд 2.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 742.3 (41.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Төрлөөр авч үзвэл сургууль, соёлын барилгын ажил 233.9 (55.4%) тэрбум төгрөгөөр, үйлдвэрийн барилгын ажил 190.6 (26.1%) тэрбум төгрөгөөр, бусад орон сууцны бус барилгынх 134.6 (35.2%) тэрбум төгрөгөөр, худалдаа, үйлчилгээний барилгын ажил 118.7 (60.7%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 64.5 (94.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээ, тэрбум төгрөгөөр



Улаанбаатар хотод 2023 онд 3.4 их наяд төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 47.7 хувийг эзэлж, өмнөх оноос 21.7 хувиар өссөн байна.

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр Өмнөговь аймагт 1.3 их наяд төгрөг, Дорноговь аймагт 387.0 тэрбум төгрөг, Дархан-Уул аймагт 293.5 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэсэн нь аймгуудын барилга угсралтын ажлын дүнд 51.9 хувийг эзэлж байна. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажил төмөр зам болон автозамын ажлууд, Дорноговь аймагт төмөр замын барилга, угсралтын ажил, Дархан-Уул аймагт зам засвар өргөтгөлийн ажил, орон сууцны барилгын ажлууд эрчимтэй явагдсан нь нөлөөлсөн байна.